

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР № 15 (ТОЙМ)

Төрийн албаны зөвлөлийн хуралдаан 2011 оны 8 дугаар сарын 03-ны өдрийн 12 цаг 30 минутанд Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөөнд болж, нийт 00 цаг 41 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын дүн, уг албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	Төрийн албаны тухай хуулийн 35.1.6, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 45.1.3 дахь заалтууд болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 34, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2011 оны 8 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн: 1. Гунгаажавын Батжаргал, Доржбалын Далайжаргал нарыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах албан тушаалтны нөөцөд бүртгэх. 2. Доржбалын Далайжаргалыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболдод санал болгохоор тогтов.
2	Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын дүн, уг албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	Төрийн албаны тухай хуулийн 35.1.6, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 45.1.7 дахь заалтууд болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 34, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2011 оны 8 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:

		<p>1.Чулуундоржийн Дарханчимэг, Даваажавын Мөнх-Эрдэнэ нарыг Говьсүмбэраймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох ажилтны нөөцөд бүртгэх.</p> <p>2.Чулуундоржийн Дарханчимэгийг Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Говьсүмбэр аймгийн Засаг дарга Ж.Баянмөнхөд санал болгохоор тогтов.</p>
3	<p>Дипломат албаны төрийн тусгай албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 61 дүгээр тогтоолоор баталсан "Дипломат албаны төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам"-ын 8 дугаар зүйлийг баримтлан 2011 оны 06 дугаар сард зохион байгуулсан Төрийн тусгай албан тушаалд анх орох мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дипломат албаны төрийн тусгай албанд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Гадаад харилцааны яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2011 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1.2011 оны 06 дугаар сарын 11, 12-ны өдөр зохион байгуулсан Дипломат албаны төрийн тусгай албан тушаалд анх орох мэргэшлийн шалгалтад тэнцсэн нэр бүхий 7 иргэнийг Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дипломат албаны төрийн тусгай албанд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх.</p> <p>2. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дипломат албаны төрийн тусгай албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэсэн иргэдээс онооны дарааллыг баримтлан өрсөлдсөн албан тушаалд нь санал болгож, томилохыг Гадаад харилцааны яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга Д.Цогтбаатарт зөвшөөрөх.</p> <p>3.Хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн, төрийн албаны мэргэшлийн шалгалтын төв комиссын</p>

4	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын тусгай албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай	<p>дарга Д.Батбаярт даалгахаар тогтов</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 63 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам"-ын 56 болон 2010 оны 20 дугаар тогтоолоор баталсан "Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам"-ын 9 дүгээр зүйлийн 9,4 дэх заалтыг тус тус баримталж, 2011 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс 23-ны өдрүүдэд Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс зохион байгуулсан цагдаа, дотоодын цэргийн байгууллагын сул орон тоог нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн тусгай албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгүүлэх тухай тус салбар зөвлөлийн саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2011 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1.Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын сул орон тоог нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн нэр бүхий 162 иргэнийг төрийн тусгай албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэж, хавсралтаар батлах.</p> <p>2.Энэхүү тогтоолын хавсралтад нэр дурдагдсан иргэдээс сонгон шалгарсан иргэдийг тухайн албан тушаалд томилуулахыг тус салбар зөвлөлийн даргад үүрэг болгох.</p> <p>3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн, төрийн албаны мэргэшлийн шалгалтын төв комиссын дарга Д.Батбаярт даалгахаар тогтов.</p>
5	Гадаад харилцааны яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3-т заасныг баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2011 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Гадаад харилцааны яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар тус яамны Төрийн</p>

		<p>захиргааны удирдлагын газрын хоёрдугаар нарийн бичгийн дарга Ё.Баттөмөрийг томилох.</p> <p>2.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 74 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 4-т “...Бямбаагийн Дашдорж” гэснийг хүчингүй болсонд тооцох.</p> <p>3.Салбар зөвлөлийн өөрт ноогдох ажлыг хууль, тогтоомж, холбогдох дүрэм, журамд чанд нийцүүлэн гүйцэтгэхийг салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Ё.Баттөмөрт даалгахаар тогтов.</p>
--	--	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

-----oOo-----